



НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН
АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2011 оны 08 сарын 18 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Зуухны зардал шийдэх тухай

Монгол Улсын “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн 17.1.1, 17.1.7 дэх заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гаалийн болон нэмэгдсэн өртгийн татвараас чөлөөлөх тухай 2011 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 2г/1934 дугаар 2011 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн 03/2802, дугаар 2011 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн дугаар г/2-1122 албан тоотуудын дагуу Буянт-Ухаа дахь гаалийн газрын түр агуулахад байгаа Канад улсын “Bose Industrial Technology” ХХК-ниас тусламжаар илгээсэн 2 ширхэг зуухыг хүлээн авах ажлыг мэргэжилтэн /М. Отгонбаярт/ даалгасугай.

2. Буянт-Ухаа дахь гаалийн газрын түр агуулахад хадгалагдаж байгаа Канад улсын “Bose Industrial Technology” ХХК-ниас тусламжаар илгээсэн 2 ширхэг зуухыг хадгалуулсаны 273.360, мэдүүлгийн үйлчилгээний 13200, тээвэрлэлтийн зардал 40.000 төгрөг, нийт 326.560 /гурван зуун хорин зургаан мянга таван зуун жаран төгрөг/- ийг холбогдох зардлаас гаргахыг ня-бо /П.Ариунаад /-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д. МӨНХЦОГ